

НОХОЙН БООРОЛТ (Өгүүллэг)

ЛҮ ШҮНЬ*

Салбархай муу хувцастай гуйлгачин
амьтан болоод гудамж уруудан гуйлга хийж
явах юм хэмээн би зүүдлэв.

Тэгтэл араас нохой боорон айсуй. Би
айсан ч янзгүй харин ширүүхэн:

- Гөлөөг өнгөтний өмнө сүүл
шарваганаж, ядуусын дэргэд шүд хавирдаг
галзуу амаа хамхи! гэв.

- Хэ, хэ! гэж тэрээр дооглоод сүнс чинь
махнаасаа дор шүү дээ! гэлээ.

- Юу? гээд миний уур манас хийж,
хүн байна даа би ингэж ч доромжлуулах

гэж дээ! гээд ичих шиг болж, өдий болтлоо
би чинь зэс мөнгө хоёрыг, торго даалимба
хоёрыг, түшмэл ард хоёрыг, эзэн зарц хоёрыг
ялгадаггүй явжээ.

Ялгаж мэдэхгүй мөн

Тийм хойно, бушуухан зугатаалаа.

Хүүе, хаачих нь вэ? Яриуштай юм байна
гэж миний араас чанга чанга хашгирах нь
сонсдов. Би, ум хумгүй ухаан жолоогүй
зугатаасаар сэрвэл орондоо хэвтэж байв.

1925 оны 4 дүгээр сарын 23

* Лү Шүнь –Хятадын их зохиолч (1881-1936). Өгүүллийг нанхиадч Д.Бандихүүгийн орчуулгаар 1962 онд хэвлэсэн “Мөнх гийгч дэнлүү” номоос авч нийтлэв.